

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ,
САНГИЙН ЯАМ БОЛОН БНСУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ КОРПОРАЦ ХООРОНДЫН
“МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТ БОЛОН 21 АЙМГИЙН ТӨВД АГААРЫН
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХАРУУЛ СУУРИЛУУЛАХ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ”
ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ХЭЛЭЛЦЭЭНИЙ
ТЭМДЭГЛЭЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ НЬ**

Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (цаашид “БОУАӨЯ” гэх), Сангийн яам (цаашид “СЯ” гэх) болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны яам (цаашид “БОЯ” гэх), Байгаль орчны корпораци (цаашид “БОК” гэх) хамтран “Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын харуул суурилуулах, чадавхыг бэхжүүлэх” төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно.

Талууд энэхүү төсөлд нэмэлт оруулж, хэлэлцээний тэмдэглэлд (цаашид “RoD” гэх) гарын үсэг зурснаар “Төсөл” –ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ойлголцож, Ажлын даалгаварт тусгасан нэмэлт өөрчлөлтийг тус тусын Засгийн газарт танилцуулахаар тохиролцов.

Хэлэлцээний тэмдэглэлийг монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж Талуудын төлөөлөгчид September 30, 2025 гарын үсэг зурав.

Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг төлөөлж:

Батын Батбаатар
Сайд

Монгол Улсын Сангийн яамыг төлөөлж:

Болдын Жавхлан
Сайд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны яамыг төлөөлж:

Ким Сонг Хван
Сайд

Бүгд Найрамдах Солонгос Улсын Байгаль орчны корпорацийг төлөөлж

Им Санг Жүн
Дарга

Ажлын даалгаварт оруулах нэмэлт өөрчлөлт

2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Талууд “Монгол Улсын Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд агаарын чанарын хяналтын харуул суурилуулах, чадавхыг бэхжүүлэх” төслийн хэлэлцээний тэмдэглэлд гарын үсэг зурснаар хэрэгжүүлж эхэлсэн болно.

Өмнө нь байгуулсан Хэлэлцээний тэмдэглэлд тусгагдсан заалтуудаас гадна, Талууд Монгол Улсын Улаанбаатар хотод агаарын чанарын хяналтын станцуудыг нэмэлтээр суурилуулах талаар хэлэлцэж, үүний үр дүнд Хэлэлцээний тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцсон болно.

1-р хэсэг: Төслийн тойм

4. Төслийн байршил

Одоогийн Хэлэлцээний тэмдэглэлд заасан Улаанбаатар хот болон 21 аймаг дахь байршлуудаас гадна, Улаанбаатар хотод агаарын чанарын станцууд нэмэлтээр суурилуулах, агаарын чанарын мэдээллийн электрон дэлгэцүүд байрлуулах зэрэг нэмэлт ажлууд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

6. Төслийн хамрах хүрээ

Талууд төслийн зорилгод хүрэхийн тулд дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсон болно.

А. 1-р бүрэлдэхүүн хэсэг: Агаарын чанарын хяналтын станцуудыг нэмэлтээр суурилуулах.

4. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Улаанбаатар хот болон 21 аймагт суурилуулах талаар одоогийн Хэлэлцээний тэмдэглэлд заасан станцуудыг Улаанбаатар хотод агаарын чанарын хяналтын 3 станцыг нэмэлтээр суурилуулах юм. Агаарын чанарын хяналтын 3 станцыг Талууд харилцан тохиролцсон байршлуудад Улаанбаатар хотод байрлуулахаар төлөвлөж байна.

5. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр PM 2,5 тоосонцор, хүхэрлэг хий (SO₂), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃), азотын ислүүд (NO_x) зэрэг үзүүлэлтүүдийг тасралтгүй хэмжих анализаторууд, PM тоосонцорын сорьц авагч, микро цахилгаан жин зэрэг агаарын чанарын хяналтын нэмэлт тоног төхөөрөмжүүдийг суурилуулна.

Е.1-р бүрэлдэхүүн хэсэг: Агаарын чанарын мэдээллийн электрон самбарыг суурилуулах.

1. Агаарын чанарын мэдээллийг олон нийтэд өгөх зорилгоор агаарын чанарын мэдээллийн электрон самбаруудыг Талууд харилцан тохиролцон Улаанбаатар хотод байрлуулна.

2-р хэсэг: Талуудын үүрэг, хариуцлага

А. Агаарын чанарын хяналтын станц суурилуулах, дэмжих үйл ажиллагаа

1. К-есо нь агаарын чанарын хяналтын станцуудыг байгуулах бөгөөд станц бүрд агаарын чанарыг хэмжих тоног төхөөрөмжүүдийг суурилуулна.

а) Агаарын чанарын хяналтын 13 станцын хэмжих үзүүлэлтүүд нь PM2.5, PM10, SO₂, NO_x, CO, O₃ байна.

б) Агаарын чанарын хяналтын 12 станцын хэмжих үзүүлэлтүүд нь PM2.5, PM10, SO₂, NO_x байна.

- Хэмжих үзүүлэлтүүд нь станц тус бүрийн байршил, бүс нутгаас хамааран өөрчлөгдөж болно.

БУСАД ЗААЛТУУД ӨӨРЧЛӨГДӨӨГҮЙ.

Хавсралт 1. Төслийн урьдчилсан хуваарь

Хавсралт 2. Агаарын чанарын хяналтын станц, нэмэлт тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсэг

Хавсралт 3. Одоогийн Хэлэлцээний тэмдэглэл

Хавсралт 2: Нэмэлт агаарын чанарын хяналтын станц болон нэмэлт багаж тоног төхөөрөмжийн нэр

No.	Багажийн нэр	Тоо ширхэг
1	Хүхэрлэг хийн анализатор, SO ₂	3
2	Азотын ислүүдийн анализатор, NO _x	3
3	Нүүрстөрөгчийн дутуу ислийн анализатор, CO	10
4	Озоны анализатор, O ₃	10
5	PM ₁₀ тоосонцорын анализатор	22
6	PM _{2.5} тоосонцорын анализатор	3
7	Агаараас тоосонцорын сорьц авагч PM (PM-10, PM-2.5)	22
8	Озон фотометртэй калибратор	3
9	Зеро генератор	3
10	Агаарын сорьц авах хоолой	3
11	Дата логгер	3
12	Ерөнхий цаг уурын хэмжилтийн багаж	3
13	19 инчийн тавиур	3
14	Агааржуулагч болон халаагч	3
15	Тог баригч, тог тогтворжуулагч, UPS, AVR	3
16	Станцын байр	3
17	Компьютер, сет	3
18	2 жилийн сэлбэг, стандарт хий	1
19	Микро электрон жин	1
20	Агаарын чанарын мэдээллийн самбар	3
21	Дамжуулах, хүлээн авах түгээх төхөөрөмж	2

* Төслийн явц, төлөв байдлаас хамааран тоног төхөөрөмжийн жагсаалт өөрчлөгдөж болно